



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/229/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8. Аудитын гол асуудал	17
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.17 № СЭА-2020/229-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,112,975.00	22,763,746.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,112,975.00	22,763,746.00
35400	Хангамжийн материал	31,112,975.00	22,763,746.00
35410	Бичиг хэргийн материал	4,652,690.00	2,959,212.00
35420	Аж ахуйн материал	22,526,485.00	19,507,185.00
35440	Түлш, шатах тослох материал	3,933,800.00	297,349.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	668,381,145.56	717,684,468.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	668,381,145.56	717,684,468.10
39200	Биет хөрөнгө	604,232,395.57	653,660,718.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	595,724,204.08	595,724,204.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,082,233.44	-46,623,350.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,495,000.00	154,495,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-92,495,000.00	-95,078,333.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	164,049,728.89	180,830,315.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-143,796,500.84	-149,330,469.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,739,255.00	59,739,255.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,398,644.91	-49,851,336.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,810,058.07	4,810,058.07
39215	Хуримтлагдсан элэгдэл	-873,971.28	-1,310,956.92
39217	Ном	60,500.00	256,332.00
39300	Биет бус хөрөнгө	64,148,749.99	64,023,749.95
39301	Программ хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-581,250.01	-706,250.05
39303	Бусад биет бус хөрөнгө	63,680,000.00	63,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	699,494,120.56	740,448,214.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	699,494,120.56	740,448,214.10
51	Засгийн газрын хувь оролцоо	699,494,120.56	740,448,214.10
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	178,942,622.54	178,942,622.54
51200	Хуримтлагдсан үр дүн	-113,824,525.02	-72,870,431.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-99,420,381.12	-113,824,525.02
51220	Тайлант үеийн үр дүн	-14,404,143.90	40,954,093.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,376,023.04	634,376,023.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	699,494,120.56	740,448,214.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	571,491,435.00	613,135,415.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,324,735.00	74,657,715.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,324,735.00	74,657,715.00
120009	Бусад орлого	310,000.00	509,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,558,195.00	73,876,419.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	456,540.00	272,096.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,166,700.00	538,477,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	562,166,700.00	538,477,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	562,166,700.00	538,477,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	585,895,578.90	572,181,321.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,895,578.90	572,181,321.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	529,879,524.30	556,127,055.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,581,297.40	386,163,000.29
210101	Үндсэн цалин	309,203,030.40	312,014,872.92
210102	Нэмэгдэл	50,533,267.00	47,019,246.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,845,000.00	12,783,873.58
210104	Урамшуулал	0	14,345,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,260,070.00	50,206,526.73
210201	Тэтгэврийн даатгал	31,456,845.00	34,812,135.21
210202	Тэтгэмжийн даатгал	3,700,806.00	3,870,654.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,960,647.00	3,073,003.77
210204	Ажилгүйдлийн даатгал	740,162.00	768,221.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,401,610.00	7,682,511.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,562,070.00	35,980,670.00
210301	Гэрэл, цахилгаан	4,091,671.00	4,616,272.00
210302	Түлш, халаалт	23,883,630.00	25,077,144.00
210303	Цэвэр, бохир ус	946,769.00	647,254.00
210304	Байрны түрээс	5,640,000.00	5,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,168,799.00	33,398,949.00
210401	Бичиг хэрэг	10,098,812.00	9,047,478.00
210402	Тээвэр, шатахуун	8,429,909.00	10,125,651.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,350,013.00	2,883,739.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	536,600.00	1,011,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,753,465.00	10,330,281.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,895,680.00	12,507,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,692,100.00	445,000.00
210604	Урсгал засвар	7,203,580.00	12,062,050.00
2107	Томилолт, зочны зардал	3,797,300.00	3,676,000.00
210702	Дотоод албан томилолт	3,797,300.00	3,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,085,800.00	4,021,763.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,651,500.00	2,054,500.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,754,700.00	1,754,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,800.00	104,863.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	18,800.00	63,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,028,507.90	29,673,096.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,028,507.90	29,673,096.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,016,054.60	16,054,265.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,516,054.60	15,054,265.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,516,054.60	15,054,265.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-14,404,143.90	40,954,093.54
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-14,404,143.90	40,954,093.54

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-113,824,525.02	699,494,120.56
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-113,824,525.02	699,494,120.56
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-113,824,525.02	699,494,120.56
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	40,954,093.54	40,954,093.54
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-72,870,431.48	740,448,214.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	562,166,700.00	538,477,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,166,700.00	538,477,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	562,166,700.00	538,477,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	562,166,700.00	538,477,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	560,582,700.00	533,377,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	560,582,700.00	533,377,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,566,645.40	517,323,434.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,581,297.40	386,163,000.29
210101	Үндсэн цалин	284,768,497.40	312,014,872.92
210102	Нэмэгдэл	64,321,700.00	47,019,246.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,839,000.00	12,783,873.58
210104	Урамшуулал	10,652,100.00	14,345,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,260,070.00	50,206,526.73
210201	Тэтгэврийн даатгал	31,456,845.00	34,812,135.21
210202	Тэтгэмжийн даатгал	3,700,806.00	3,870,654.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,960,647.00	3,073,003.77
210204	Ажилгүйдлийн даатгал	740,162.00	768,221.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,401,610.00	7,682,511.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,562,070.00	35,980,670.00
210301	Гэрэл, цахилгаан	4,091,671.00	4,616,272.00
210302	Түлш, халаалт	23,883,630.00	25,077,144.00
210303	Цэвэр, бохир ус	946,769.00	647,254.00
210304	Байрны түрээс	5,640,000.00	5,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,054,108.00	22,376,224.00
210401	Бичиг хэрэг	9,341,950.00	7,354,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,200,000.00	5,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,350,013.00	2,883,739.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	536,600.00	1,011,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,625,545.00	5,146,685.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,276,000.00	14,399,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,276,000.00	2,220,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	12,179,250.00
2107	Томилолт, зочны зардал	3,797,300.00	3,676,000.00
210702	Дотоод албан томилолт	3,797,300.00	3,676,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,535,800.00	4,021,763.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,101,500.00	2,054,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,754,700.00	1,754,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,800.00	104,863.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	18,800.00	63,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,016,054.60	16,054,265.98

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,516,054.60	15,054,265.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,516,054.60	15,054,265.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,584,000.00	5,100,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,584,000.00	5,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,584,000.00	5,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,584,000.00	5,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,584,000.00	5,100,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,584,000.00	-5,100,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	538,477,700.00	523,423,434.02	15,054,265.98	97.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,477,700.00	523,423,434.02	15,054,265.98	97.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,477,700.00	522,423,434.02	15,054,265.98	97.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,570,200.00	386,163,000.29	6,407,199.71	98.37
210101	Үндсэн цалин	300,649,600.00	312,014,872.92	-11,365,272.92	103.78
210102	Нэмэгдэл	64,321,700.00	47,019,246.79	17,302,453.21	73.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,946,800.00	12,783,873.58	4,162,926.42	75.44
210104	Урамшуулал	10,652,100.00	14,345,007.00	-3,692,907.00	134.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,889,900.00	50,206,526.73	4,683,373.27	91.47
210201	Тэтгэврийн даатгал	38,545,000.00	34,812,135.21	3,732,864.79	90.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,086,200.00	3,870,654.88	215,545.12	94.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,269,000.00	3,073,003.77	195,996.23	94.00
210204	Ажилгүйдлийн даатгал	817,200.00	768,221.11	48,978.89	94.01
210205	Эрүүл мэндийн даатгал	8,172,500.00	7,682,511.76	489,988.24	94.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,962,300.00	35,980,670.00	1,981,630.00	94.78
210301	Гэрэл, цахилгаан	5,280,600.00	4,616,272.00	664,328.00	87.42
210302	Түлш, халаалт	25,370,100.00	25,077,144.00	292,956.00	98.85
210303	Цэвэр, бохир ус	1,311,600.00	647,254.00	664,346.00	49.35
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,640,000.00	360,000.00	94.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,722,200.00	22,376,224.00	345,976.00	98.48
210401	Бичиг хэрэг	7,354,000.00	7,354,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,600,000.00	5,980,000.00	-380,000.00	106.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,658,200.00	2,883,739.00	774,461.00	78.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	1,011,800.00	-51,800.00	105.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,150,000.00	5,146,685.00	3,315.00	99.94
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500,000.00	19,499,250.00	750.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,320,000.00	7,320,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	12,180,000.00	12,179,250.00	750.00	99.99
2107	Томилолт, зочны зардал	3,797,300.00	3,676,000.00	121,300.00	96.81
210702	Дотоод албан томилолт	3,797,300.00	3,676,000.00	121,300.00	96.81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,535,800.00	4,021,763.00	1,514,037.00	72.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	3,101,500.00	2,054,500.00	1,047,000.00	66.24

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,754,700.00	1,754,700.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139,800.00	104,863.00	34,937.00	75.01
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	63,800.00	63,700.00	100.00	99.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	538,477,700.00	523,423,434.02	15,054,265.98	97.20
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	538,477,700.00	523,423,434.02	15,054,265.98	97.20
310001	Улсын төсвөөс санхүүжих	538,477,700.00	523,423,434.02	15,054,265.98	97.20
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	48	48	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	2	2	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	2	2	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0.00	100.00
650012	Шүүгч, прокурор	4	4	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын / цаашид Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газар гэх / 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт, анхан шатны баримтыг зааврын дагуу бүрэн хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газар нь “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны зорилт, чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хамгаалах,
- Шүүхийн зохион байгуулалт, захиргаа, хүний нөөцийг удирдах,
- Төсвийг төлөвлөх, санхүү, дэд бүтцийг удирдах,
- Шүүгчдийг мэдээллээр хангах, олон нийттэй харилцах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 66 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг тус газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт хийж, бүртгэл тайлагналтай холбоотой 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 585,895.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,858.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 4,394.2 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,954.1 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	31,113.0	22,763.7	(8,349.3)
Үндсэн хөрөнгө	668,381.1	717,684.5	49,303.4
Нийт хөрөнгө	699,494.1	740,448.2	40,954.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	699,494.1	740,448.2	40,954.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	699,494.1	740,448.2	40,954.1

Бараа материалын дансны үлдэгдэл 22,763.7 мянган төгрөг болж 8,349.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 27,829.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 781.3 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 36,960.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,060,585.2 мянган төгрөг болж 78,976.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон 73,876.4 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг ШЕЗ-өөс тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 740,448.2 мянган төгрөг болж 40,954.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 41,644.0 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 65,333.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 13,714.3 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Энэ нь цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 16,528.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 7,230.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, урсгал шилжүүлэг 39,961.8 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 693,947.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 155,469.4 мянган төгрөгөөр бууруулж, 538,477.7 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Энэ нь цалин, НДШ-ийн зардал 14,027.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 23,590.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 87,755.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 17,055.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 5,700.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **538,477.7** мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 538,477.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **523,423.4** мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 11,090.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,981.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,514.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, оны эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130405401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцлох ажил гүйлгээ, асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,198.9 мянган төгрөгийн албан шаардлага, зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	818.5	1	818.5	100
Зөвлөмж	3	13,380.4	3	13,380.4	100
Нийт дүн	1	14.198.9	1	14.198.9	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 4,344.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 4,344.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд шатахууны норм, зарцуулсан хэмжээг бүрэн бүртгээгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул цаашид жолоочийн тооцооны хуудасны холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мандал сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар	2	4,344.3	-	-	-	-	-	-	2	4,344.3